



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/133

Есөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.2.2, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.2 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ахмад настны хөгжил, оролцоог дэмжиж сум, тосгоны Ахмадын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 100,000,000 (зуун сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Сум, тосгоны Ахмадын хорооны үйл ажиллагааны зардалд зориулж олгосон 5,0 сая төгрөгийн зарцуулалтад хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн Ахмадын хорооны дарга (С.Галсанчоймбол)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

